**“БҮХ НИЙТИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ**
**2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**
**(2024 он)**

2024.11.29 Дархан-Уул аймаг

| № | Бодлогын үндэслэл (Алсын хараа-2050) | Зорилго, зорилт, үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2024 оны зорилтот түвшин | 2024 оны хэрэгжилт | Хэрэгжилт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 1. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох | | | | | | | |
| 1 | 1.2.3<br>1.4.1<br>1.1.15 | Үйл ажиллагаа 1.1 Соёлын боловсрол олгох албан бус сургалтын агуулга, хөтөлбөр боловсруулах | Хөтөлбөр, агуулгын тоо, хөтөлбөрт хамрагдсан хүний тоо | Музейн боловсролын хөтөлбөр-8, Соёлын боловсролын сургагч багшийн анхан шатны хөтөлбөр-1 | Сургалтын хөтөлбөрийн тоог 2-оор нэмэгдүүлэх | Тус аймгийн Музей нь “Мандала”, “Мартан”, “Нагтан”, “Оюуны цэнгэл”, “Оюуны зангилаа”, “Уран зураг уншихуй”, “Аав ээж би”, “Бүтээлч гар”, “Бяцхан гар”, “Шинэ дурсамж”, “Мэдлэгийн хүрд” зэрэг 13 боловсролын хөтөлбөрийг 362 удаа зохион байгуулж 8836 иргэдийг хамруулсан.<br>- Аймгийн Төв номын сан нь "Монгол бахархал", "Эсгий урлал", "Хайрлахуйн ухаан", "Уран зангилаа", "Саная, холбоё, сэтгэе, бодоё" зэрэг 5 боловсролын хөтөлбөрийг 36 удаа зохион байгуулж 1036 хүнийг хамруулсан.<br><br>- Хүүхдийн номын ордон нь хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээгээр дамжуулан соёлын боловсрол олгох “Угийн бичгээ хөтөлж сурцгаая”, “Уламжлалт тоглоом наадгай”, “Өв соёлоо мэдье”, “Даам тоглож сурцгаая”, “Номтой аялал-Морин хуур”, “Олбог оёж сурцгаая” зэрэг 6 боловсролын хөтөлбөрийг 95 удаа /давхардсан тоогоор/ зохион байгуулж, 5855 уншигчийг хамруулсан.<br><br>-Сумдын соёлын төвүүд нь "Зүү ороох оёдол", "Уламжлалт тоглоом наадгай", "Хөгжмийн зэмсгийн мэдлэг олгох", "Ургийн модоо бүтээх", "Амттай уншлага", “Иогтой ном” зэрэг нийт 15 боловсролын хөтөлбөрийг 93 удаа зохион байгуулж 2131 хүүхдийг хамруулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | | | | | | -"Бүх нийтийн соёлын боловсрол" хөтөлбөрийн хүрээнд МУ-ын СББӨ-ийг хамгаалах чадавхыг бэхжүүлэх сургагч багш бэлтгэх 2 дахь шатны сургалтад аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2 албан хаагч хамрагдсан.<br>**Үр дүн: Соёл урлагийн 7 байгууллага нь 39 төрлийн боловсролын хөтөлбөрийг 586 удаа соёлын боловсролын 17,858 хүүхдийг хамруулсан.** | |
| 2 | | Үйл ажиллагаа 1.2 Нүүдлийн соёлын боловсрол олгох жишиг хөтөлбөр батлах | Батлагдсан жишиг хөтөлбөрийн тоо | - | Хилийн чанад дах хүүхэд багачуудад зориулсан Нүүдлийн соёлын боловсрол олгох жишиг хөтөлбөр-1 | Аймгийн Соёл, урлагийн газар, Музей нь Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл” өвийг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулсан “Монгол гэр” үзэсгэлэнд удирдамжийн дагуу амжилттай оролцсон. Үзэсгэлэнгээр нүүдлийн соёлын боловсрол олгох хүрээнд “Монгол гэр хэрхэн үүсэж хөгжсөн түүх”, “Оюуны цэнгэл” уламжлалт наадгай, “Хөөрхөн Нада” хөлөгт наадгай, “Аман яруу найраг-оньсого”, “Нада-тай цуг Найрамдлын Музейгээр аялая” зурагт комик, “Хорол, үйчүүр наадгай” хөтөлбөрийг зохион байгуулж 17,706 иргэнд үйлчилсэн.<br>-2024 оны 08 дугаар сарын 16-аас 18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд аймгийн Музейгээс "Хорол", "Үйчүүр", "Оюуны цэнгэл", "Шагайн наадгай", “Монгол гэр хэрхэн үүсэж хөгжсөн түүх” зэрэг соёлын өв, уламжлалт тоглоом наадгай болон "Хөөрхөн Нада-тайгаа цуг хөлөгт тоглоом тоглоцгооё" боловсролын хөтөлбөрүүдийг зохион байгуулж 1100 гаруй иргэдэд сурталчлан таниулсан.<br>-Мөн "Хөөрхөн Нада-тайгаа цуг хөлөгт тоглоом тоглоцгооё" боловсролын хөтөлбөрт ЕБС-ийн 250 гаруй сурагчдыг хамруулсан.<br><br>**Үр дүн: “Монгол гэр хэрхэн үүсэж хөгжсөн түүх” боловсролын хөтөлбөрийг** | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **хэрэгжүүлж байна.** | |
| 3 | | | Нүүдлийн соёлын боловсрол олгох хөтөлбөр хэрэгжүүлэх зуслангийн тоо | 1 зусланд хөтөлбөр хэрэгжүүлж байсан. | 3 | - Тус газрын харьяа соёлын 3 байгууллага нь Зулзагын гол хүүхдийн зуслангийн амрагч хүүхдүүдэд Нүүдлийн соёлын боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг тус газрын даргаар батлуулж ажиллав. Энэ хүрээнд 2024.07.04- нөөс 1 сарын хугацаанд **дээрх** зусланд амрагч **1680** хүүхдэд соёлын өв, нүүдлийн ахуй соёл, уламжлалыг таниулах 13 соёлын боловсролын хөтөлбөрийг зохион байгуулсан.<br>- "Дэлхийн мөрөөдлийн сургууль" НҮТББ 2024 онд тус аймагт анх удаа нүүдлийн соёлын зуслан хэрэгжүүлсэн. Нийт 100 орчим ахлах ангийн сурагчид хамрагдаж Монгол өв уламжлал, ахуйн соёлын боловсролыг өөрсдийнхөө оролцоонд суурилсан хөтөлбөрөөр дамжуулан авсан.<br>**Үр дүн: Аймгийн хэмжээнд 1 зусланд хөтөлбөр хэрэгжүүлж, Нүүдлийн соёлын зуслан шинээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн.** | 100% |
| 4 | | Үйл ажиллагаа 1.5 Соёлын байгууллагын үйл ажиллагаа, уран бүтээлийн бодлогыг соёлын боловсрол олгоход чиглүүлж, хөтөлбөртэй байгууллагын тоог нэмэгдүүлэх | Соёлын боловсролын хөтөлбөр баталгаажуулсан байгууллагын тоо | - | Баталгаажуулсан хөтөлбөртэй байгууллагын тоо-70 | Соёлын боловсролын хөтөлбөртэй байгууллагын тоо 7. Үүнд: Залуучууд театр, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Шарын гол, Орхон, Хонгор сумдын соёлын төвүүд нь нийт 39 боловсролын хөтөлбөрийг зохион байгуулсан. | 100% |
| 5 | | Үйл ажиллагаа 1.6 “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам”-ын | Гаргасан санал, санаачилга, зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүн | - | Хамтын ажиллагааг сайжруулах, хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулах. 21 аймаг, | - Тус газрын харьяа соёлын 7 байгууллагад Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмын хэрэгжүүлж ажиллах тухай чиглэлийг албан бичгээр хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>- Залуучууд театр, сумдын Соёлын төвийн дэргэд хичээллэж буй 24 дугуйлангийн багш | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилтийг хангаж ажиллах | | | 330 сум, 9 дүүрэгт чиглэл хүргүүлэх | нарт болон 269 суралцагч, соёлын салбарын 10 албан хаагчийг хамруулсан сургалтыг тус тус зохион байгуулж журмыг сурталчилсан.<br>- Соёлын байгууллагууд нь “Хөшиг нээгдэх бүрт хүргэх нэг үг” уриалгын хүрээнд уг журмын заалтуудыг сурталчилж байна.<br>- Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран Спортын тэмцээн уралдаан, Үдшийн цэнгүүн, Ойн арга хэмжээнүүд болон хүүхдийн хөгжлийг дэмжсэн 16 удаагийн урлагийн тоглолтын үеэр журмын хэрэгжилтэд хяналт тавьж зөвлөмж өгч ажилласан. Жилийн эцсийн байдлаар гомдол, санал гараагүй.<br>- Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Цагдаагийн газраас Төрийн байгууллагуудын дунд зохион байгуулсан байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтад Соёлын салбарын 16 албан хаагч хамрагдсан.<br>- Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Биеийн тамир спортын газартай хамтран 2024.10.24-нд төрийн 12 байгууллага, хувийн хэвшлийн 10 гаруй дугуйлан, клуб, секц, холбооны 90 гаруй багш, ажилтнуудад Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмыг танилцуулах сургалтыг зохион байгуулсан.<br>- Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь аймгийн Аудитын газарт журмын хэрэгжилтийг хангаж ажилласан тухай тайланг хүргүүлж хяналт, шалгалтад орсон.<br>- Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжилтэд 2024.11.18-ны өдөр аймгийн Хүүхдийн эрхийн улсын байцаагч хяналт тавьж баримт бичигтэй танилцаж зөвлөмж өгсөн. Мөн 2024.11.19-ний өдөр тус газрын 11 албан хаагч Хүүхдийн эрхийн улсын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байцаагч А.Мягмаржаргалаас Хүүхэд, гэр бүлд ээлтэй бодлого болон байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг хэрхэн хэрэгжүүлэх тухай сургалтыг авлаа.<br>-“Ирээдүйгээ сонсъё” уриан дор зохион байгуулагдсан “Дэлхийн хүүхдийн өдөр”-өөр соёлын 7 байгууллага 20 арга хэмжээ зохион байгуулж 418 хүүхдийг хамруулсан. | |
| Зорилт 2. Эко систем бүрдүүлэх | | | | | | | |
| 6 | 1.2.5<br>1.2.8,<br>1.4.3,<br>1.4.6,<br>1.1.15<br>1.1.19 | Үйл ажиллагаа 2.1 Соёлын боловсролын судалгаа хийх | Соёл, урлагийн боловсролын судалгааны тоо | 5 | ХБИ-ийн соёлын хэрэгцээг тодорхойлох судалгаа-1,<br>Нэвтрүүлэг, контентын агуулгын мониторинг судалгаа-1,<br>Нөхцөл байдлын судалгаа-1 | Тус газрын харьяа Соёлын байгууллагууд 5 удаагийн сэтгэл ханамжийн судалгаанд 555 хүнийг хамруулж үйл ажиллагаандаа ашигласан байна. Үүнд:<br>- Залуучууд театр нь уран бүтээлийн чанар төрөл, хэрэгцээ шаардлага, сэтгэл ханамжийн түүвэрчилсэн судалгаанд нийт 410 үзэгч,<br>- Төв номын сан Уншигчийн сэтгэл ханамжийн судалгаанд 31 уншигч,<br>- Ном хэвлэлийн хүрэлцээ хангамжийн судалгаанд 27 уншигч хамрагдав.<br>- Хүүхдийн номын ордон нь сэтгэл ханамжийн судалгааг 2 удаа хийж 87 сурагчийг тус тус хамруулсан.<br>-Сумдын соёлын төвүүд үйлчилгээний чанарыг судалгаанд 228 иргэдийг хамруулав. | 90% |
| Зорилт 3. Хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах | | | | | | | |
| 8 | 1.4.1,<br>1.4.3 | Үйл ажиллагаа 3.1 Соёлын боловсролын үндэсний сургагч багшийг бэлтгэх, мэргэшүүлэх | Сургалтын тоо<br>Бэлтгэгдсэн үндэсний сургагч багшийн тоо | сургалт-1<br>Багш-60 | Сургалт-2<br>Ахисан түвшинд-30, анхан түвшинд 30 багш бэлтгэх | -2024.05.24-ний 01/316 тоот албан бичгийн дагуу "Бүх нийтийн соёлын боловсрол" хөтөлбөрийн хүрээнд МУ-ын СББӨ-ийг хамгаалах чадавхыг бэхжүүлэх сургагч багш бэлтгэх сургалтад аймгийн Соёл, урлагийн газрын 2 албан хаагч хамрагдсан.<br>-2024.05.27, 28-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо аймгийн Төв номын сангийн Захирал, Соёлын боловсролын сургагч багш Б.Цэцэгсүрэн Үндэсний номын сангийн шинэ байрны нээлтэд оролцож номын сангийн шинэ системийн танхимын сургалтад хамрагдсан. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | | Үйл ажиллагаа 3.2 Соёл, урлагийн боловсролын сургагч багш бэлтгэх, мэргэшүүлэх | Сургалтад хамрагдсан ЕБС-ийн багшийн тоо | Сургалтад хамрагдсан ЕБС-ийн багш-238, Эхний жил-155, Тав дахь жил-55, Арав дахь жил-38 | 352-оор нэмэгдүүлэх, Эхний жил-182, Тав дахь жил-115, Арав дахь жил-55 | - | |
| 1 0 | | | Сургалтад хамрагдсан СӨБ-ын багшийн тоо | Сургалтад хамрагдсан СӨБ-ын багш-72 | 95-аар нэмэгдүүлэх | Хүүхдэд бага наснаас нь үндэсний үнэт зүйл, эх хэл бичиг, түүх, соёл, зан заншил, өв уламжлал, соёл, эх оронч үзэл, ёс суртахууны цогц чадамжийг төлөвшүүлэх, соёлын боловсролыг сургуулийн өмнөх насанд төлөвшүүлэх зорилгоор 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн хүүхдийн цэцэрлэгийн арга зүйч, бүлгийн багш, дуу хөгжмийн багшийн төлөөлөл бүхий 100 багш "Соёлын боловсролын сургагч багш"-аар бэлтгэгдсэн. Тус аймгаас 10 багш хамрагдсан. | 100% |
| 11 | | | Залуучуудын хөгжлийн төв, Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн сургалтад хамрагдсан мэргэжилтний хувь | - | 15 хувьд хүргэх | - Залуучуудын хөгжлийн төв, Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн 1 сургалтад 2 мэргэжилтэн хамрагдсан.<br>-"Эерэг сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих төсөл"-ийн "Сэтгэл зүйн нөөцөө хэрхэн үр дүнтэй удирдах вэ?" сургалтад 11 албан хаагч хамрагдсан.<br>-2024.11.03-нд "Гэр бүлийн хөгжил, хамгаалал" сэдэвт сургалтад тус газрын мэргэжилтэн гэр бүлийн хамт хамрагдсан. | 100% |
| 12 | | | Сургалтад хамрагдсан хэвлэл мэдээллийн ажилтны тоо | - | 50-аар нэмэгдүүлэх | - "Цахимд хэвшье" танхимын сургалтад 2 албан хаагч, Creativehub системийн танхимын сургалтад 12 албан хаагч хамрагдав.<br>- Хөвсгөл аймагт 2 сарын 28-3 сарын 2-ны хооронд зохион байгуулсан МСНЭ-ийн хойд бүсийн форумд 8 төлөөлөгч оролцсон.<br>- Булган аймагт 4 сард зохион байгуулсан 21 аймгийн сэтгүүлчдийн форумд 1 төлөөлөгч оролцсон.<br>- 2024 оны 4 сарын 4-д зохион байгуулсан "Мэдрэмжтэй мэдээлье" сургалтад тус аймгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сэтгүүлч, хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтнууд хамрагдсан.<br>- Хэвлэлийн Хүрээлэнгээс 9 сарын 15-ны өдөр гар утсаараа контент бэлдэх, эвлүүлэх чадвар /МОЖО/ сургалтыг зохион байгуулж тус сургалтад 2 сэтгүүлч хамрагдлаа.<br>- “Монгол Улсад хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн салбарыг бэхжүүлэх нь” (MACSS) төслийн хүрээнд Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол төвийн бүсийн сургалтыг 9 сарын 21-22-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт зохион байгуулсан бөгөөд сургалтад Сэлэнгэ, Булган, Орхон, Дархан-Уул аймгийн төлөөллүүд оролцлоо.<br>- 2024 оны 10 дугаар сарын 28-нд зохион байгуулсан Сэтгүүл зүйн чанар ба төлөөлөл” хуралд МСНЭ-ийн Дархан салбарын сэтгүүлчид хамрагдав. Энэ үеэр тус аймгийн DBS телевизийн сэтгүүлч Э.Бодьгэрэл өөрийн бүтээлийн түүхээ хуваалцлаа. Түүний бэлтгэсэн телевизийн сурвалжилга нь “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийн виртуал редакцын 9 дүгээр сарын шилдэг бүтээлийн нэгээр шалгарсан юм.<br>- Улаанбаатар хотод 11 сард зохион байгуулсан Хэвлэлийн зөвлөлийн сургалтад 1 сэтгүүлч хамрагдсан.<br>**Давхардсан тоогоор 57 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд сургалтад хамрагдаж мэргэшил ур чадвараа дээшлүүлсэн байна.** | |
| Зорилт 4. Иргэдэд эерэг, бүтээлч хандлага төлөвшүүлэх, сургалт нөлөөллийн аян хэрэгжүүлэх | | | | | | | |
| 13 | 1.2.1, 1.2.3, 1.4.2, 1.5.2, 1.5.8, 2.1.20, | Үйл ажиллагаа 4.1 Хүний хөгжлийн үечлэл бүрд чиглэсэн соёл, урлагийн боловсролыг дээшлүүлэх сургалт, арга хэмжээ зохион | Үндэсний бичиг соёл, номын өдрийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний тоо, | Арга хэмжээ-186, Оролцогчид-220,000 | Арга хэмжээ-190 Оролцогчдын тоог 5 хувиар нэмэгдүүлэх | "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд 2024" хавар, намрын номын баярын хүрээнд аймгийн Төв номын сан 54 арга хэмжээг 117 удаа зохион байгуулж 20308 хүн, Хүүхдийн номын ордон 29 арга хэмжээнд 4386 хүн, Шарын гол сумын Соёлын төв 13 арга хэмжээнд 862 хүн, Хонгор сумын Соёлын сум 10 арга хэмжээнд 290 хүн, Орхон сумын соёлын төв 8 арга хэмжээнд 198 хүнийг тус тус хамруулж нийт 114 арга хэмжээг 125 удаа зохион байгуулж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах | оролцогчды н хувь | | | 26,044 хүнийг хамруулаа.<br>- Тус аймгаас "Хаврын номын баяр"-ын хүрээнд зарласан “Номын сайн нөхөр” улсын уралдаанд ЕБС-ийн сургуулийн 6 анги, уншигчийн материалыг хүргүүлж ажилласан. Уралдаанд "Од" цогцолбор сургуулийн 5-10 ангийн хамт олон “Тэргүүний шилдэг уншигч хамт олон”-оор шалгарч 2024.05.28-ны өдөр Улаанбаатар хотноо "35 дахь Номын баяр"-ын нээлтийн үеэр УИХ-ын дарга Г.Занданшатараас шагналаа гардан авсан.<br>-Хоёр удаагийн номын баярын нээлтэд 50 гаруй байгууллагын 1734 иргэн оролцож 7886 иргэд хүрэлцэн ирж үзэж сонирхсон. | |
| 14 | | | Соёл, урлагийн сургалт дугуйланд хамрагдсан суралцагчийн тоо | Сургалт дугуйлан-2380 Сургалтад хамрагдагчид-38208 | Сургалтын тоог 5 хувиар, Суралцагч ийн тоог 5 хувиар нэмэгдүүл эх | Тус газрын харьяа соёлын 6 байгууллагын дэргэдэх нийт 24 сургалт, дугуйланд 4404 суралцагч суралцсан байна. Үүнд:<br>- Залуучууд театр нь драмын 2, дууны 1, хөгжмийн 4, бүжгийн 3, циркийн 1 нийт 11 дугуйлантай хамтран ажиллах гэрээ хийж дэмжин ажиллаж байна. Тус дугуйлангуудад нийт 130 хүүхэд суралцдаг.<br>- Төв номын сан шатрын дугуйланг 150 удаа, Англи хэлний сургалтыг 2 удаа зохион байгуулж 1650 хүүхдийг хамруулсан.<br>- Хүүхдийн номын ордон нь Монгол хэл, бичиг-уран зохиол, Байгалийн ухаан, Гадаад хэл, Цахим ном-мэдээлэл, Book & coffee зэрэг төрөлжсөн 5 танхимуудаар давхардсан тоогоор 2380 хүүхдэд үйлчилж, 16889 ном хэвлэл болон хоцрогдол арилгах, бие даан суралцахад нь тусалж давтлага өгч үйлчилжээ.<br>- Шарын гол сумын Соёлын төв хүүхэд хөгжүүлэх 1 дугуйланд 84 хүүхдийг хамруулсан.<br>- Орхон сумын Соёлын төв бүжиг, хөгжим, цахилгаан хөгжим зэрэг 3 дугуйланд 94 хүүхдийг хамруулсан.<br>- Хонгор сумын Соёлын төв нь дуу, бүжгийн 2 дугуйланд 66 хүүхдийг хамруулсан. | 100% |
| 15 | | | Хүүхэд, өсвөр үеийнхэнд соёл, | Арга хэмжээ-6 багц | Арга хэмжээг 10-аар, | “Оюунлаг Дархан” хөтөлбөрийн хүрээнд Оюунлаг дархан өдөрлөгийг 55 удаа зохион байгуулж 12185 хүүхдийг хамруулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүмүүжил, хайрлах, хүндэтгэх эерэг, бүтээлч хандлага төлөвшүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн цогц арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн тоо | Төсөл-19 | Төслийг 5-аар нэмэгдүүлэх | - Соёлын байгууллагууд хамтран “Эх оронч Дарханы ирээдүй” өдөрлөгийг 5 хоногийн хугацаанд зохион байгуулж урлагийн тоглолт, лекц илтгэл, сэдэвчилсэн номын үзэсгэлэн, уралдаан тэмцээн зэрэг нийт 6 арга хэмжээнд 435 хүүхэд, багачуудыг оролцуулсан бөгөөд сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 6 удаа 555 боть номоор гаргав.<br>-"Зохиолч, яруу найрагчдын уулзалт"-ыг 5 удаа зохион байгуулагдаж, 642 хүүхэд хамрагдсан байна.<br>- “Уран жиргээ 2024” уран уншлагын 2 удаагийн уралдаанд 116 хүүхэд оролцов.<br>- "Хэл бичгээ өвлөн бахархъя" эсээ бичлэгийн уралдаанд нийт 63 иргэн хамрагдсан.<br>- "1000 ном уншлагын хөтөлбөр"-ийн сургалтад соёлын байгууллагууд болон ЕБС, СӨББ-ийн 60 гаруй багш нарыг хамруулсан.<br>-“Үлгэрээс үлгэрлэе” чанга уншлага, тойм яриаг бага насны хүүхдүүдийн дунд 18 удаа, 34 өгүүллэгээр зохион байгуулж, 957 хүүхэд хамрагдлаа.<br>-Дүрийн тоглолт бүтээх уралдааныг 5 удаа зохион байгуулж 356 хүн, “Алтан хонх” уралдаанд 33 хүүхдийг хамруулав.<br>-“Хүүхдийн уншлагыг удирдахуй”, “Үр дүнтэй уншлага” хэлэлцүүлэгт 120 хүн, Хурдан уншлагын уралдаанд 80 сурагч хамрагдсан.<br>-“Найргийн даага” яруу найргийн уралдаанд 72 хүүхэд, “Би зохиолч” хүүхдийн яруу найргийн наадамд 69 хүүхэд, “Номтой аялал” 164, “Мэргэжил бүхэн сайхан” соёлын байгууллагатай танилцах аялалд 24 хүүхдийг хамруулсан.<br>-"Дөрвөн бэрх урлъя" эсгий урлалын сургалтад 18 албан хаагч хамрагдав.<br>-"Угийн бичгээ хэрхэн хөтлөх вэ?” сэдвээр 6 удаа сургалт зохион байгуулж 293 иргэн оролцов.<br>-“Ном унших арга зүй” сургалтыг 5 удаа зохион байгуулж 168 хүүхдийг хамруулсан.<br>-“Гал Өд-2024” яруу найргийн наадмыг тус газар, МЗЭ-ийн Дархан-Уул аймаг дахь салбар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамтран улсын хэмжээнд 3 үе шаттайгаар зохион байгуулсан. 21 аймгаас 50 гаруй яруу найрагч оролцож 250 гаруй иргэд, уншигчид үзэж сонирхов.<br>-“Номтой өдөр”, “Эх хэлний дархлаа”, “Зохиолчдын номтой өдөрлөг” зэрэг өдөрлөгүүдэд 1960 хүүхэд оролцов.<br>-"Полифони" Дуэт болон Квартет дуучдын улсын уралдаанд Баянхонгор, Дорнод, Өвөрхангай, Дорноговь, Дархан-Уул, Улаан-Үд зэрэг нийт 6 аймаг, хотын 28 багш, 212 хүүхэд, багачууд оролцсон.<br>**Үр дүн: Хүүхэд, өсвөр үеийнхэнд соёл, хүмүүжил, зэрэг, бүтээлч хандлага төлөвшүүлэх чиглэлээр 27 арга хэмжээнд 18,305 хүүхдийг хамруулсан.** | |
| 16 | | | Залуучуудад эерэг, бүтээлч хандлага төлөвшүүлэх, оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээний тоо | 4 багц арга хэмжээ | Арга хэмжээг 5-аар нэмэгдүүлэх | **Тус аймгийн Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөл нь тайлант хугацаанд нийт 7 арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:**<br>1. 2024.01.31-нд 2024 оны анхдугаар хурлаа хийж зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилсэн.<br>2. 2024.02.01-нд "Мөнгөн өвөл-2024" цасны баярыг Соёл, урлагийн байгууллагуудын 90 гаруй ажилтны дунд зохион байгуулав. 2024.03.12-нд аймгийн Биеийн тамир, спортын газраас цасны баярыг амжилттай зохион байгуулсныг үнэлэн өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнав.<br>3."Дэлхийн номын өдөр" /2024.04.23/ аймгийн Төв номын сантай хамтран зах, худалдааны төвүүдээр үйлчлүүлж буй 50 гаруй иргэдийн дунд танин мэдэхүй хөгжөөнт "АХА" тэмцээнийг зохион байгуулсан.<br>4.Аймгийн Музейтэй хамтран "Darkhan walking festival-50” 10 км-ын уртын алхалтад 7 албан хаагч нэгдэж алхлаа.<br>5.Соёл, урлагийн ажилтны өдрийг Хонгор сумын соёлын төвтэй хамтран зохион байгуулж “Залуу манлайлал” сургалт, хэлэлцүүлгийг соёлын байгууллагын 40 гаруй албан хаагчдын дунд зохион байгуулав.<br>6. “Хөрөг зураг” нээлттэй өдөрлөгийг зохион | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулав.<br>7.Шинэ жилийн арга хэмжээг соёлын салбарын ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | |
| 17 | | | Гэр бүлд чиглэсэн соёлын боловсролын хөтөлбөр, арга хэмжээний тоо | Гэр бүлийн боловсролын хөтөлбөр-8<br>Амьдрах ухааны хөтөлбөр-11<br>Зэрэг хандлагын хөтөлбөр-1 | Хөтөлбөр, арга хэмжээ-2 | **Гэр бүлд чиглэсэн соёлын боловсрол олгох 29 томоохон арга хэмжээг зохион байгуулсан. Тухайлбал:**<br>1. Соёлын байгууллагуудын “Эцэг эхийн зөвлөл”-өөс 108 хүүхдийн тусламжийн утсыг таниулах, Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таних, бүх хэлбэрийн хүчирхийлэл дарамт, эрсдэлийг илрүүлэх чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор нийт 12 удаагийн нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.<br>2."Аз жаргалын дуран" гэр бүлийн селфи гэрэл зургийн уралдааныг "Солонго" гэрэл зургийн студитэй хамтран зохион байгуулсан. Тус уралдаанд 14 гэр бүл оролцож 8 гэр бүлийг шалгаруулж шагнан урамшуулсан.<br>3.Төв номын сан Дэлхийн номын өдрөөр "Гэр бүлийн ном солилцоо"-г зохион байгуулж 56 иргэнийг хамруулсан.<br>4. Хүүхдийн номын ордон Дэлхийн гэр бүлийн өдөр сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 52 боть номоор дэглэж Монгол-Оюу сургуулийн 5а ангийн сурагчид, багш, эцэг эхчүүтэй хамтран “Номч гэр бүл”, “Бид нэг гэр бүл” өдөрлөг зохион байгуулж 72 хүнийг хамруулсан.<br>5. “Дэлхийн хүүхдийн өдөр”-өөр соёлын байгууллагууд 20 арга хэмжээ зохион байгуулж 418 хүүхдийг хамруулсан.<br>6. “Гэр бүлийн хөгжил, хамгаалал” сэдэвт сургалтад 1 албан хаагч хамрагдсан.<br>7. 2024.05.24-ний өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан "Монгол гэр бүл" өдөрлөгт тус аймгаас “Шинэ үе Хамтын холбоо” ТББ-ын “Урам” төв оролцож “Монгол наадгай” хөлөгт тоглоомоо сурталчлан таниулж “Уламжлалт Хөлөгт тоглоом”, “Шагайн наадгайн ач холбогдол” сэдвээр илтгэл тавив.<br>8.Дархан сумын айл, өрхүүдийн дунд “Угийн бичиг”-ийн уралдааныг зохион байгуулж эхний 3 байр шалгаруулан шагнан урамшуулав. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 9.Төв номын сан аймгийн 30 дугаар цэцэрлэгтэй хамтран "Хүүхэд хүмүүжүүлэхэд эцэг эхийн оролцоо" сэдэвт сургалтыг зохион байгуулав.<br>10. Шарын гол сумын Соёлын төв "Авьяаслаг гэр бүл" видео контентэд 10 гэр бүлийг оролцуулж цахимаар 564 хүнд хүргэсэн. | |
| 18 | | | Ахмад настанд чиглэсэн соёлын арга хэмжээний тоо, оролцооны хувь | Арга хэмжээ-28 Оролцоо-44,000 | Арга хэмжээ-15 Оролцогчдын тоог 2 хувиар нэмэгдүүлэх | - Аймгийн Музей нь СББӨ-ийг өвлөн уламжлагч Б.Очирмаатай хамтран “Уламжлалт аргаар сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах” сургалтыг 2 удаа зохион байгуулж 20 гаруй ахмад настанг хамруулсан. Тус сургалтаар цагаан идээ хийх арга, боловсруулсан бүтээгдэхүүнээ хэрхэн хатаах, хэрхэн удаан хадгалах зэрэг технологийг заасан.<br>-Хүүхдийн номын ордон нь 9 ахмад настан, 10 хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон тусгаарлах байрны 9 уншигчид үнэ төлбөргүй карт нээж, 6 удаа 166 боть номоор зөөврийн номын сангийн үйлчилгээ үзүүлсэн. Өндөр настан 3 уншигчид гэрээр ном олгох үйлчилгээг 6 удаа үзүүлж 14 боть ном хүргэсэн.<br>- Шарын гол сумын Соёлын төв "Ургийн модоо бүтээцгээе" сургалтыг 30 ахмад настанд зохион байгуулав. Мөн сар шинийн баярын үеэр сумын 6 ахмадад хүндэтгэл үзүүлсэн.<br>- Орхон сумын Соёлын төв ахмадуудаа жил бүр хүлээж авдаг бөгөөд Сум орон нутгийнхаа ахмад настанд чиглэн үйл ажиллагаа бүрийн араас нийтийн цэнгээнт бүжиг зохион байгуулдаг. 2024 оны хагас жилийн байдлаар нийт 56 ахмад нарт үйлчилгээ үзүүлсэн.<br>- Хонгор сумын Соёлын төв нь 2 арга хэмжээ зохион байгуулж 68 ахмадыг хамруулсан.<br>- Ахмадын байгууллагатай хамтарсан “Дуулах өдөр” дуун цэнгүүнийг зохион байгуулж 32 ахмад хамрагдсан байна.<br>-Соёлын байгууллагууд ахмадын баярыг тохиолдуулан байгууллагын тэтгэвэрт гарсан 17 ахмадыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэв.<br>-Төв номын сан “Угийн бичгээ хөтөлж сургаая” сургалтыг 2 удаа зохион байгуулж 75 хүнийг хамруулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Дархан сумын Ахмадын хороотой хамтран "Уншихад урам" монголын уран зохиолын дүрийн тоглолтын уралдааныг зохион байгуулж 60 ахмадууд оролцов.<br>**Нийт 10 арга хэмжээ зохион байгуулж 395 ахмадыг хамруулав.** | |
| 19 | | | Зорилтот бүлгийн иргэдэд зориулсан арга хэмжээний тоо | Сургалт-3<br>Арга хэмжээ-10 | ХБИ-2, Хилийн чанадад амьдарч байгаа монголчуудад чиглэсэн арга хэмжээ-2 | - Соёлын байгууллагууд 5/1 аяны хүрээнд тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэдэд сар бүр хүнсний болон бусад зүйлээр тусламж үзүүлж байна.<br>- Аймгийн Музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, СББӨ-ийг өвлөн уламжлагчид тус аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн холбоо” ТББ-тай хамтран 2024 оны 03 дугаар сараас эхлэн 18 хүртэлх насны 129 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэнд 6 удаа соёлын боловсролын хөтөлбөрөөр үйлчилсэн.<br>- Номын сангийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ялгаваргүйгээр тэгш хүргэх, уншигчдад тохирсон дэд бүтэц, орчин нөхцөлийг бүрдүүлэх, номын баяжилт, техник хэрэгслээр хангаж хүртээмжийг сайжруулах зорилгоор "Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсны үр дүнд Төв номын санд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан техник тоног төхөөрөмжийн төслийг орон нутгийн 60 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр болов.<br>- Соёл, урлагийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх ажлын хүрээнд соёлын байгууллагууд түр хамгаалах байр болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо, “Урам төв”-тэй хамтран соёлын боловсролын 19 хөтөлбөрийг 109 удаа зохион байгуулж 5402 хүнд хүрч үйлчилсэн.<br>- Залуучууд театр нь “Миний хөөрхөн шүдний аялал” хүүхдийн хүүхэлдэйн жүжгийг 400 гаруй зорилтот болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үнэ төлбөргүй үзүүлэв.<br>-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих аяны хүрээнд “Шидэт чулууны эрэлд” арга хэмжээг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэмжин хамтран ажилласан.<br>-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн үйл ажиллагааны нээлтийн арга хэмжээнд зориулсан “Тэгш хөгжье” өдөрлөгт техник тоног төхөөрмжөөр дэмжлэг үзүүлэв.<br>-Музейн захирал Д.Жамбалдорж, Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Газартай хамтран гэр оронгүй тусгай хэрэгцээт 20 иргэдэд “Амьдралаа шинэчилье-Дархандаа сайхан амьдарья” сэдэвт лекцийг зохион байгуулав.<br>-Зорилтот бүлгийн иргэдэд зориулж соёлын байгууллагууд урлаг соёлын үйл ажиллагаанд болон уншлага үйлчилгээнд үнэ төлбөргүй хамруулж ажиллаж байна.<br>-Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч С.Одонцоо Хотон угсаатны бий биелгээ, ахуйн зан заншлыг 20 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эцэг эхчүүдэд заан сургав.<br>-“Хамтдаа Хөгжье” хөгжлийн бэрхшээлтэй 1, 2-р ангийн сурагчдын боловсролын үйлчилгээний талаарх хэлэлцүүлэгт 2 албан хаагч хамрагдсан.<br>-Тусгай хэрэгцээт иргэд Дархан хотын баяраар флашмоб бүжиглэж “Өөдрөг байгаарай” дууг дохионы хэлээр дуулав.<br>**Нийт 12 арга хэмжээнд 5973 хүнийг хамруулсан.** | |
| 20 | 1.1.14<br>1.2.1,<br>1.3.8,<br>1.4.6,<br>1.5.1,<br>1.5.2 | Үйл ажиллагаа 4.2 Нийгмийн харилцааны соёлыг төлөвшүүлэх, "Хүүхдэд ээлтэй Монгол" хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн үндэсний чуулганы зөвлөмжийг хэрэгжүүлэх | Иргэдийн соёл, урлагийн боловсролыг дээшлүүлэхэ эр зохион байгуулсан нөлөөллийн аяны тоо | 1 | 6-аас доошгүй нөлөөллийн аян зохион байгуулах | **Тус газрын харьяа Соёлын байгууллагууд нийт 14 төрлийн аянд нэгдэн ажилласан. Үүнд:**<br>- “Энэ жилдээ, эрүүл жиндээ”, "Авлигын эсрэг таслан зогсооё", "Нийгэм соёл, төлөвшлийн төлөө", "Хамтаар амьдрах", "Цахимд хэвшье”, "Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй", "Харамсахгүй төлөө хамтдаа", “Мотоцикл ба хамгаалах малгай”, “Ирээдүйгээ сонсъё”, “Жендэрийн эрх тэгш байдал”, “Соёл танаас эхэлнэ”, “Хүүхэд бидний ирээдүй”, “Соёлын бүтээлч сар-2024”, “Байгууллагаараа уншигч болцгооё” зэрэг аянуудад тус тус нэгдэн нөлөөллийн ажлыг хийж цахимд байршуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | | чиглэлээр бүх шатны байгууллага, иргэдийг уриалсан нөлөөллийн аяныг зохион байгуулах | Нийгмийн соён гэгээрлийг дээшлүүлэх эд чиглэсэн нийтлэл, нэвтрүүлэг, контент, тоглоом, хэвлэмэл бүтээл, уран бүтээлийн тоо | 59 | 60-аас доошгүй бүтээл бэлтгэж, түгээсэн байх | 1. UBS телевизийн "21 Өв, соёл" нэвтрүүлэгт тус аймгийн Залуучууд театрын уран бүтээлч, морин хуурч, МУСТА Г.Мөнгөншагай оролцов.<br>2. “Монгол Түмний Мэнд” нэвтрүүлэгт МУ-ын Үндэсний өв соёл цоллоочдын холбооны тэргүүн, Улсын моръ, бөх цоллооч, МУСТА, Ерөөлч магтаалч, СББӨ-ийн 3 дахь үеийн өвлөн уламжлагч Б.Дарханнямын гэр бүл оролцов.<br>3. Цэц.мн цахим сайттай хамтран Монголын сор бүтээлүүдийг монгол бичгээр буулгаж, торгоор баринтагласан “Эвхмэл судар”, олон ястны дуунуудыг буулгасан “Хуйлмал ном” –ын тухай нэвтрүүлэг бэлтгэж олон нийтэд хүргэсэн.<br>4. “Бидний номын сан” видео бичлэгийн уралдаанд 14 хүн оролцсон.<br>5. Цэц.мн цахим сайттай хамтран бүтээсэн "Өвлөн уламжлъя”- Үндэсний ёс заншил, өв уламжлал, монгол ахуйгаа сурталчилсан контентэд 27 дугаар цэцэрлэгийн хүүхдүүд оролцов.<br>6. Шарын гол сумын Соёлын төв "Авьяаслаг гэр бүл" видео контентэд 10 гэр бүлийг оролцуулж цахимаар 564 хүнд хүргэсэн.<br>7. RGB телевизийн “Өв соёлын цаг” нэвтрүүлэгт “Шагайн наадгайн төрөл”, “Шагайн наадгай” сэдвээр 2, “Дээл” сэдвээр 1 видео контент тус тус бэлтгэж цахимд байршуулан 1474 хэрэглэгчдэд хүргэсэн.<br>8. Зөөврийн номын сангийн үйлчилгээний "Номын богц", Монгол үндэсний хувцас, дээлний гарал үүслийн тухай видео контентыг бэлтгэж цахимд байршуулж 1350 хүнд хүргэв.<br>9. RGB телевизтэй хамтран “Найрамдлын Дархан өргөө” контент бэлтгэсэн.<br>10. Музейн Сан хөмрөгт хадгалагдаж буй 9 төрлийн хөлөгт тоглоомыг судалгааны эргэлтэд оруулах, түүгээр дамжуулан иргэдэд СББӨ-ийг түгээн дэлгэрүүлэх, уламжлалт тоглоом наадгайг сургах, сурталчлан таниулах, түүнийг өвлөн суралцах боломжийг олгох зорилгоор “Хөөрхөн Нада” хөлөгт наадгайн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тоглоомын багцыг худалдаанд гаргасан.<br>11. Аймгийн Музей “Нада аялал найрамдлын музейд” комик зургийн ном, “Найрамдлын Дархан өргөө” гэрийн танилцуулга, Шинэ үе хамтын холбоо ТББ, Тусгай хэрэгцээт залуучуудыг дэмжих "УРАМ" төвөөс санаачлан "МОНГОЛ НААДГАЙ" хөлөгт тоглоом нь 5 цуврал, 80 хөлөгтэй, 89 тоглоомтой, Цахим QR тайлбартай хөлөгт тоглоомыг хэвлэн иргэд олон нийтэд хүргэсэн.<br>12.Ахмадын хөгжлийн төвтэй хамтран "Өв соёл-Цагаан сар" сургалтыг зохион байгуулсан.<br>13. МЗЭ-ийн гишүүн, Зохиоллч, яруу найрагч Л.Мөнхбаатарын бие даасан 6 дахь уран бүтээл болох "Янзын залуу минь яруу найраг зураглаач" шинэ номын нээлтэд 40 хүнийг хамруулав.<br>14. “Найргийн даага” яруу найргийн уралдаанд 72 хүүхэд, “Би зохиолч” хүүхдийн яруу найргийн наадамд 69 хүүхэд, “Номтой аялал” 164, “Мэргэжил бүхэн сайхан” аялал 24 хүүхдийг тус тус хамруулсан.<br>15.“Номтой өдөр”, “Эх хэлний дархлаа”, “Зохиолчдын номтой өдөрлөг” зэрэг өдөрлөгүүдэд 1960 хүүхэд оролцов.<br>16. “Гал Өд-2024” яруу найргийн наадмыг тус газар, МЗЭ-ийн Дархан-Уул аймаг дахь салбар хамтран улсын хэмжээнд 3 үе шаттайгаар зохион байгуулсан. 21 аймгаас 50 гаруй яруу найрагч оролцож 250 гаруй иргэд, уншигчид үзэж сонирхов.<br>17.“Ном унших арга зүй” сургалтыг 5 удаа зохион байгуулж 168 хүүхдийг хамруулсан.<br>18.“Хүүхдийн уншлагыг удирдахуй”, “Үр дүнтэй уншлага” хэлэлцүүлэгт 120 хүн, Хурдан уншлагын уралдаанд 80 сурагч хамрагдсан.<br>19. “Уухайн түрлэгт эх орон минь” 4 аймгийн хамтарсан хүндэтгэлийн тоглолтод 220 уран бүтээлч оролцож 520 хүн үзэж сонирхов.<br>20.Номонд дурлагсад контент бэлтгэн, цахимд байршуулж 12877 хүнд хүрсэн.<br>21.Ахмад номын санч Д.Лидагийн Хүндэт иргэний тухай ярилцлага, Ч.Бадамцэцэгийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Дархан-Уул аймаг хэвлэлийн хуудаснаа” шинэ номын агуулга тайлбарын тухай ярилцлагаар тус тус контент бэлтгэн 867 хүнд хүргэв.<br>22.Төвийн бүсийн номын санчдыг чадавхжуулах сургалт, зөвлөгөөнд 5 аймгийн 100 гаруй номын санч хамрагдсан.<br>23."Найрамдалын Дархан" баярын тоглолтод Залуучууд театр, Сэлэнгийн долгион чуулга, Төв аймгийн “Монгол туургатан" театр, Улан-Үдэ хотын Хоца Намсраевын нэрэмжит Буряад драмын театрын нийт 70 гаруй уран бүтээлчид оролцсон.<br>24.“Хотын соёл надаас эхэлнэ” эсээ болон видео бичлэгийн уралдаанд 35 хүүхэд оролцов.<br>25.”Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль”, “Монгол гэр үзэсгэлэн”, “Мэргэжил бүхэн сайхан”, “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024”, “Миний хөөрхөн шүдний аялал”, “Дархан хот залуусын нүдээр”, “Монголын зохиолчдын эвлэлийн Дархан салбар” болон “Төв номын сан”-ийн 60 жилийн ойн баярын арга хэмжээ, "Сайхан шинлээрэй", "Мэдрэхүй", СББӨ-ийг өвлөн уламжлагч, Н.Мөнгөнбаяр, Ж.Эрхэмсайхан, Б.Түмэннаст, Т.Сарантуяагий талаар ярилцлагын нэвтрүүлэг, МЗЭ-ийн Дархан салбарын тэргүүн, зохиолч Р.Лхамрагчаагийн "Сүбээдэй баатар" хөлгөн тууль", "Ардын дууны түрлэг" нэвтрүүлэг “Хөлөгт тоглоом бол ой ухааны дасгал” нэвтрүүлэг, "Номонд дурлагсад”, "Эргэх дөрвөн цаг", “Шилдэг уншигч анги хамт олон”, “Найрамдын Дархан өргөө”, “Үндэсний бичиг-Манай хамт олон” уралдаан, “Полифони” кват болон дуэт улсын уралдаан, зэрэг нэвтрүүлэг зэрэг нийт 68 нэвтрүүлгийг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран иргэд олон нийтэд сурталчилсан. | |
| 22 | | | Хүүхэд хөгжлийн төвтэй, соёлын бүтээлч орон | 38 | 5-аар нэмэгдүүлэх | Соёлын бүтээлч орон зай бүрдүүлсэн байгууллагын тоо-7 Үүнд:<br>- Залуучууд театр нь соёлын орон зай, соёлын орчин бүрдүүлж, соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд зөөврийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зай бүрдүүлсэн байгууллагын тоо | | | тайз, дэлгэцтэй болсон.<br>-“Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл” өвийг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Найрамдлын Дархан өргөөтэй болсон. Тус гэрээр дамжуулан “Монгол гэр хэрхэн үүсэж хөгжсөн түүх”, “Оюуны цэнгэл” уламжлалт наадгай, “Хөөрхөн Нада” хөлөгт наадгай, “Аман яруу найраг-оньсого”, “Нада-тай цуг Найрамдлын Музейгээр аялая” зурагт комик, “Хорол, үйчүүр наадгай” хөтөлбөрийг зохион байгуулж 17,706 иргэдэд үйлчилсэн.<br>-Номын сангийн уншигч, үйлчлүүлэгчдэдээ зориулан эрүүл мэндийн "Анхны тусламжийн хайрцаг", "Санал хүсэлт"-ийн хайрцагийг тус тус байршуулан хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн.<br>-Хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээгээр дамжуулан соёлын бүтээлч орон зайг бүрдүүлэх зорилгоор "Угийн бичиг", "Даам тоглож сурцгаая" танхим, кино урлагаар дамжуулан соёлын боловсрол олгох орчин бүрдүүлсэн.<br>-“Бий биелгээний шавь сургалтын танхим”-ыг Хүүхдийн номын ордонд нээж 2024.05.29-өөс 06.04-ний өдрүүдэд 20 гаруй хүүхэд багачуудад Хотон бий биелгээний сургалтыг Увс аймгийн Тариалан сумын Соёлын төвийн дарга, МУСТА, Бий биелгээний багш Х.Түмэнжаргал өвлүүлэн уламжлуулав.<br>- Шарын гол сумын соёлын төв “Vip cinema” буюу хүүхдэд тав тухтай мини кино танхимыг шинээр ашиглалтад оруулж 72 үзэгч хамруулав.<br>- Орхон сумын Соёлын төв шатарын дугуйлангийн хүүхдүүдэд суралцах орчиноор хангаан ажиллав. Мөн ЕБС-ийн сурагчдыг спортоор хичээллэх нөхцөлийг хангаж спорт заалыг үнэ төлбөргүй ашиглуулж байна.<br>- Соёлын 7 байгууллага хүүхдэд зориулсан амралтын өрөөг бий болгон ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | 1.1.7,<br>1.3.7,<br>1.4.3, 1.4.4,<br>1.4.8,<br>1.5.3, 1.5,7, | Үйл ажиллагаа 4.3 Соёлын өвийн боловсролыг өвлөн уламжлуулж, түгээн дэлгэрүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулах | Монгол хэл, бичгийн хэрэглээний соёлыг төлөвшүүлэх ээр зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | Арга хэмжээг 10-аар нэмэгдүүлэх | -Харьяа соёлын 6 байгууллага **“Эх хэлний өдөр”-**ийг тохиолдуулан нийт 8 арга хэмжээ зохион байгуулж 312 хүнийг хамруулсан. **Үүнд:** Төв номын сан 1 үйл ажиллагаанд 32 хүн, Хүүхдийн номын ордон 2 үйл ажилгаанд 128 хүн, Шарын гол, Орхон, Хонгор сумын Соёлын төвүүд 5 үйл ажиллагаанд 152 хүнийг тус тус хамруулсан байна. Мөн энэ үеэр соёлын байгууллагууд шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн, Уншлага үйлчилгээг зохион байгуулав.<br>-Бүх нийтийн соёлын боловсролын хүрээнд Эх хэл түүх соёлоо эрхэмлэн дээдэлсэн, эрүүл чийрэг, эх оронч, бүтээлч Монгол хүүхдийг төлөвшүүлэхэд чиглэсэн 10 арга хэмжээг зохион байгуулсан байна. Тэдгээрт нийт 1035 хүүхдийг хамруулсан.<br>- Тус аймгийн Соёл, урлагийн байгууллагууд 2024 оны жилийн эцсийн байдлаар нийтдээ 62 арга хэмжээ, 16 сургалт, хэлэлцүүлэг 32 зурагт хуудас контент, албан бичиг 412, албан хаагчийн нэрийн хуудас 24 ажилтны ажлын үнэмлэх болон ажлын байрны гадна болон дотор хаягжилтыг монгол бичгээр үйлдэх зэргээр олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.<br><br>-Хүүхдийн номын ордон ЕБС-ийн ахлах ангийн 80 сурагчийн дунд “Хүмүүн бичиг” сонины дугаараас "Чингисийн чулууны бичиг”, "Цогтын хадны бичээс” сэдвээр “Хурдан уншлага”-ын уралдаан зохион байгуулав.<br><br>-Аймгийн СУАЖЗГ, Төв номын сан хамтран “Чингисийн чулууны бичиг, Цогтын хадны бичээс буюу Дуутын хар хөшөө”-ний талаарх сургалтыг ЕБС-ийн ахлах ангийн 60 сурагчийн дунд зохион байгуулав. | 100% |
| 24 | | | Монгол хэл, бичгийн нийтийн хэрэглээний орчин | 10 | Арга хэмжээг 10-оор нэмэгдүүл эх | -"Хос бичигтэн-2025" эрдэм шинжилгээний хурал ЕБС-ийн 32 багшийг хамруулсан.<br>-Монгол бичгийн цахим болон танхимын 6 сургалтад 123 хүнийг хамруулсан байна.<br>-Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо | | | судалгаанд 15 албан хаагч хамрагдсан.<br><br>-“Эх хэл зөв уншлага” АХА танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулж 32 сурагч оролцсон.<br><br>- Харьяа номын сангуудтай хамтран үндэсний бичиг, үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх хүрээнд "Бийрэн бичлэг", "Уран уншлага"-ын сургалт, уралдааныг 24 удаа зохион байгуулж 153 хүнийг хамруулсан.<br><br>-Сурагчдын бийрэн бичлэгийн бүтээл болон 54 боть номоор үзэсгэлэн дэлгэж 62 сурагчийг хамруулав.<br><br>-Үндэсний бичгийн "Түргэн уншлага", "Хэл бичгээ өвлөн бахархъя" эссэ бичлэг, "Эх хэлээ эрхэмлье" сайхан бичгийн уралдаанд нийт 460 иргэнийг хамруулсан.<br><br>-Соёлын байгууллагууд "Хүмүүн бичиг" сонинг улирал бүр захиалж өглөөний уншлага хийж хэвшсэн.<br>-Иргэдийн эх хэлний мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор цахимд 14 удаа нийтлэл оруулж 1659 хүнд хүргэсэн.<br>-“Эх хэлний дархлаа” өдөрлөгийг зохион байгуулж 130 гаруй хүүхэд хамрагдаж 12 хүүхдийг шалгаруулж байр эзлүүлэв.<br><br>-“Үндэсний бичиг-Манай хамт олон” цахим контент бэлгэх уралдааныг 20 гаруй байгууллагын 4000 иргэд оролцсон.<br>-Хэлний бодлогын зөвлөлийн Дархан салбартай хамтран “Миний бахархал” бийр, хулсан үзгийн үзэсгэлэнг хамтран зохион байгуулав. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 25 | | | Соёлын биет бус өвийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах | 30 | 10-аар нэмэгдүүлэх | Тайлант хугацаанд Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг дэмжих, тоглолт, шавь сургалт зохион байгуулах, сурталчлах, алдаршуулах чиглэлээр нийт 12 арга хэмжээг зохион байгуулж 420 хүн хамрагдсан байна. Үүнд:<br>1. 2024.01.20-нд СББӨ-ийг өвлөн уламжлагч 14-р багийн иргэн, СББӨ-ийг өвлөн уламжлагч Б.Очирмаатай хамтарсан "уламжлалт аргаар сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах" практик сургалтыг зохион байгуулав. Сургалтад 14 иргэн хамрагдав.<br><br>2. 2024.01.20-нд СББӨ-ийг өвлөн уламжлагч, "Үндэсний Өв Соёлын Холбоо"-ны тэргүүн Б.Дарханням "Монгол ёс заншил" сургалтыг аймгийн Музейд зохион байгууллаа. Сургалтад 20 гаруй гэр бүл хамрагдав.<br><br>3. 2024.02.05-нд Соёлын өвийн үндэсний төв, МҮОНРТ-тэй хамтран "Монгол түмний мэнд" нэвтрүүлэгт СББӨ-ийг өвлөн уламжлагч Монголын өв соёлын холбооны тэргүүн Б.Дарханнямын гэр бүл Дархан-Уул аймгаа төлөөлж оролцов.<br><br>4. 2024.02.05-нд СББӨ-ийн 3 дахь үеийн өвлөн уламжлагч, "Нүүдэлчдийн өв соёл, шүтлэг" ТББ-ын Тэргүүн О.Туулын "Эрүүл аж төрөх ёс" өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр О.Туул нь өөрийн нагац өвөө Ч.Ёндоршарав, авга өвөө С.Доржгочоо нараас өвлөгдөн, уламжилж ирсэн 1935 оны үеийн Орос хүн Монголруу нэвтрэх зөвшөөрлийн бичиг, Говийн Лха бурханы модон барын дардас, 1911-1925 оны үеийн засаг захиргаа, шүүх яамны холбогдолтой дүрэм, өргөх бичиг, тогтоол, тухайн үеийн ДХЯамны анхны 13 офицерийн гэрэл зураг болон Утга зохиол сонины анхны дугаар зэрэг 50 гаруй зүйлсийг дэлгэн, олон нийтэд сонирхууллаа. Сургалтад 50 гаруй иргэд хамрагдав.<br><br>5. 2024.01.30-нд ЮНЕСКО, Соёлын яамны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэмжлэгтэйгээр СУИС-ийн Соёлын сургуулиас хэрэгжүүлж буй “Монгол бий биелгээг өвлүүлэн уламжлуулж, оршин тогтнох чадварыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд “Бий биелгээний шавь сургалтын танхим”-ыг тус аймагт нээлээ. Танхимын нээлтэд Дархан, Орхон, Хонгор сумын 15 бий биелээчид оролцов.<br><br>6. UBS телевизийн "21 Өв, соёл" нэвтрүүлэгт аймаг орон нутгийн онцлог, өв уламжлалыг харуулсан тус нэвтрүүлэгт Залуучууд театрын морин хуурч, МУСТА Г.Мөнгөншагай оролцов.<br><br>7. Монгол үндэсний өв соёлыг хадгалж уламжлан өвлүүлэх зорилгоор аймгийн Ахмадын хөгжлийн төв, Соёл, урлагийн газар, Дархан сумын ЗДТГ хамтран “Өв соёл-Цагаан сар” уулзалт сургалтыг зохион байгуулж ажиллав. Сургалтад Дархан сумын ЗДТГ, Багийн Засаг дарга, нийгмийн ажилтнууд нийт 120 иргэд хамрагдав.<br><br>8. “Нүүдэлчдийн өв соёл, шүтлэг” ТББ-ын Тэргүүн О.Туул "Gen-Z ба Монгол соёл" сэдвийн хүрээнд Монгол өв соёлоороо дамжуулан өсвөр насны хүүхдүүдийн харилцаа, хандлага хүмүүжил, хувцаслалт, хоол хүнс, орчин үеийн сошиал хэрэглээний зохистой хэрэглээний талаар сургалтыг зохион байгуулав. Сургалтад "Дархан Өргөө" ПТК, "Оюуны Ирээдүй" Цогцолбор, "Монгол Оюу", "Од" цогцолбор, 1, 4, 9, 15, 16, 19 дүгээр сургуулийн 3-12 дугаар ангийн нийт 40 гаруй сурагчид хамрагдав.<br><br>9. Монгол улсаас ЮНЕСКО-ийн жагсаалтад бүртгэгдсэн 15 өв болон Морин хуур, Монгол Ардын уртын дуу, Монгол бий биелгээ, Монголын Уламжлалт Хөөмийн урлаг, Монгол уран бичлэг өвийг эзэмшсэн 22 өвлөн уламжлагчдад "БАТЛАМЖ" гардуулав.<br><br>10. 2025.05.17-нд Олон улсын Музейн өдрийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тохиолдуулан Орхон сумын Соёлын төв, аймгийн Музей хамтран СББӨ-ийг өвлөн уламжлагчдын дунд "ӨВ СОЁЛОО ДЭЭДЭЛЬЕ" өдөрлөгийг зохион байгуулав. Өдөрлөгт Орхон сумын 22 СББӨ-ийг өвлөн уламжлагч хамрагдав.<br><br>11. СББӨ-ийг өвлөн уламжлагч, Орхон сумын 2 дугаар багийн малчин М.Даваанямтай хамтран Мал маллах арга ухаан цахим контен бэлтгэн цахимаар 268 хүнд хүргэв.<br><br>12. СББӨ-ийг өвлөн уламжлагч Дархан сумын 5 дугаар багийн иргэн Г.Мягмарын угийн бичиг хөтлөх зааврыг олон нийтэд танилцуулах зорилгоор цахим контент бэлтгэн цахимаар 565 хүнд хүргэсэн. | |
| 26 | | | | | | | |
| 27 | | | Түүх, соёлын хөдлөх дурсгалын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах | 86 | 20-оор нэмэгдүүлэх | 1. Шарын гол сумын Хайрхан багийн нутаг дэвсгэрт орших "Буган чулуун хөшөө" дурсгалыг тус багийн иргэн Д.Мядагсүрэн, “Найрамдал өндөрлөг” хөшөөг “Цэгц туургатан” ХХК-д хариуцуулан хамгаалах, хамтран ажиллах 3 талт гэрээг байгуулсан.<br>2. Дархан сумын 14 дүгээр багийн нутаг дэвсгэрт орших Найрамдал өндөрлөг, Лимбэчин хүү, Эх үрсийн элбэрэл, Буга баримал хөшөөг Дархан хотын соёл, амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-т гэрээгээр хариуцуулах, хамгаалах, хамтран ажиллах 3 талт гэрээг байгуулав. Гэрээний хүрээнд Лимбэчин хүү, Эх үрсийн элбэрэл хөшөөний гадна өнгө төрхийг сэргээн засварлах ажлын төсвийн талаар хэлэлцэв.<br>3. Орхон, Шарын гол сумын Соёлын төвд СББӨ-ийн өвлөн уламжлагчдын тоо болон чанарыг нэмэгдүүлэх, Музейн эд өлгийн зүйлийг бүртгэн баримтжуулах, холбогдох шинэ дүрэм, журмыг таниулах, ТСҮХД-ын хадгалалт хамгаалалтыг хэрхэн сайжруулах зэрэг мэдээллийг олгох зорилгоор “Түүх, Соёлын Үл Хөдлөх Дурсгалын тухай болон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Дархан-Уул аймгийн дурсгалуудын мэдээлэл", "Соёлын Биет Бус Өв, түүний төрөл болон Дархан-Уул аймгийн СББӨ-ийн мэдээлэл", "Соёлын үнэт зүйл худалдан авах журам", "Сан хөмрөгт үзмэр оруулах гаргах хөдөлгөө"-ний дүрэм, "Түүх, Соёлын Хөдлөх Дурсгалт зүйлийн төрөл зүйлийн танилцуулга" зэрэг сэдвийн хүрээнд арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.<br>4. Хонгор сумын нутагт орших Түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох 5 ширхэг дурсгалыг шинээр бүртгэн баримтжуулав. Бүртгэлд 3 хөшөө дурсгал, 1 үйлдвэрлэлийн ул мөрийн дурсгал, хиргисүүрийг тус тус тусгай маягтын дагуу бүрдүүлэн ажиллаж, гэрэл зургаар баримтжууллаа.<br><br>Тайлант хугацаанд 2 үл хөдлөх түүх соёлын дурсгалт хөшөө, Музейн 3 үзмэрийн гадаад өнгө төрхийг сэргээн засварласан. Сан хөмрөгт хадгалагдаж буй 358 дэсийн 518 гэрэл зургийг цахимжуулж цахим архивт хадгалах ажлыг 40 хувийн гүйцэтгэлтэйгээр хийсэн. | |
| 28 | | | Баримтат өвийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах | 3 | 2-оор нэмэгдүүлэх | Тайлант хугацаанд тус аймгийн харьяат 1 иргэний гэрт хадгалагдаж буй 17, 1 хийдийн 4, Музейн сан хөмрөгт хадгалагдаж буй 6, нийт 50 дэсийн соёлын баримтат өвийг бүртгэн баримтжуулав. Үүнд: Баримт бичиг-5, зурмал бурхан-17, ном сонин-1, Зураг-5, ил захидал 1, марк-12, баримтат өв-9 | 100% |
| 29 | | | Хүүхэд багачуудад зориулсан нүүдэлчдийн язгуур урлагийн арга хэмжээ зохион байгуулах | Зохиогдсон арга хэмжээний тоо - 2 | 7-аар нэмэгдүүлэх | -21 аймгийн уртын дуучид", "Сайхан шинэлээрэй", Тал нутгийн залуус", "Наргиант бий", "Тойрон бүжиг", "ӨВ Соёлоо дээдэлье", "Авъяаслаг шинэ алхамчууд", "Бий биелгээний танхимын нээлт", Мэргэжил сурталчилах өдөрлөг зэрэг тоглолт, үйл ажиллагаа,<br>-"Монгол түмний мэнд", "21 өв, соёл", "Ардын дууны түрлэг", "Өвлөн уламжлъя", "Сар шиний мэнд", "Өв соёлын цаг" монгол ёс заншлаа сурталчилсан контент, нэвтрүүлэг<br>-Үндэсний хөгжмийн талаар сургалт танхимаар 3 удаа, цахимаар 8, СББӨ-ийг өвлөн | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | уламжлагч 4 иргэний танилцуулга, бэлтгэж цахимаар иргэд, олон нийтэд сурталчилсан.<br>-Залуучууд театр болон Шарын гол, Орхон, Хонгор сумдын Соёлын төвийн дуу, бүжгийн дугуйланд нийт 269 хүүхэд хамрагдаж байна. | |
| 30 | | Үйл ажиллагаа 4.4 Иргэдийн урлагийн боловсролыг дээшлүүлэх, сурталчилгаа, танин мэдэхүйн арга хэмжээг зохион байгуулах | Дуу хөгжим, тайзны урлагийн мэдлэг ойлголтыг өгөхөөр зохион байгуулсан арга хэмжээний тоо | 39 | 10-аар нэмэгдүүлэх | -Bee theatre Софокл "Эдип хаан" эмгэнэлт жүжгийг Дархан хотын ЕБС-ийн сурагчдад 2 удаа тоглож 800 гаруй сурагчид театрын урлагаар дамжуулан уран зохиолын хичээлийн боловсрол олгов.<br>-Урлагийн соёлын боловсрол олгох ажлын хүрээнд ЕБС-ын 300 гаруй хүүхдэд "Мэргэжил сурталчлах" өдөрлөг зохион байгуулсан.<br>-"Хөгжмийн зэмсгийн мэдлэг олгох" сургалтыг 4 удаа зохион байгуулж 148 хүүхдийг хамруулсан байна.<br>-Дээлтэй Монгол өдөрлөг 2 удаа зохион байгуулав.<br>**-“Өв соёлоо дээдэлье”** тоглолтод 21 оролцогч оролцож 355 хүн оролцов.<br>-“Морин хуур”-ыг сурталчлан таниулах сургалтыг 7 удаа зохион байгуулж 312 хүнийг хамруулав.<br>- Шарын гол Соёлын төвийн дэргэдэх бүжгийн дугуйлангийн 15 сурагч “Монгол бүжгийн гайхамшиг 2024” тэмцээнд амжилттай оролцов.<br><br>- “OPEN MIC” арга хэмжээг 4 удаа зохион байгуулж 856 хүүхдийг хамруулж ажилласан.<br>-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас зохион байгуулсан “Соёлын төв,ордны дуу гэрлийн техникчдийн чадавхыг бэхжүүлэх, мэргэшүүлэх нь” танхимын сургалтад Дархан-Уул Орхон Соёлын Төвийн техникч И.Ганзориг хамрагдаж 2 кредит цагийн гэрчилгээг гардан авсан. | 95% |
| 31 | | | Кино, контент, дүрсний урлагийн боловсрол, шүүмж | 8 | 3-аар нэмэгдүүлэх | - “Соёлын түүчээ 330” төслийн хүрээнд сумдын Соёлын төвүүдэд нийт 16 киног 611 үзэгч, Залуучууд театрт 3 киног нийт 9 удаа 1970 гаруй үзэгчдэд хүргэлээ.<br>- Тус аймагт 2024 онд нийт 5 киноны зураг авалт хийгдлээ. Дээрх киноны зураг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сэтгэлгээг хөгжүүлэхээр зохион байгуулсан арга хэмжээний тоо | | | | авалтуудын орчин, байршил, багийн гишүүдийн байрлах байр, оролцох уран бүтээлчид, олны хэсгийн бүрдүүлэлт зэргийг дэмжин сурталчилан ажиллалаа.<br>- “Хамгийн сайхан нь 2” УСК-ны нээлтийг хамтран зохион байгуулж киноны найруулагч О.Батзоригт “Найрамдлын Дархан” тэмдгийг гардуулсан.<br>- Залуучууд театрын хүүхдийн шинэ уран бүтээл “Муурын байшин” жүжгийн бяцхан жүжигчид Цэц.мн сайттай хамтран “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” аянд нэгдэж контент хийн уриалгыг цахим орчинд байршууллаа.<br>-Залуучууд театрын шинэ уран бүтээл “Миний хөөрхөн шүдний аялал” хүүхдийн хүүхэлдэйн жүжгийг 14 удаа тоглож 4493 хүүхдийг хамруулсан.<br>-Залуучууд театрын уран бүтээлчид “Эгшиглэнт аялгуу” явуулын тоглолтыг 4 удаа зохион байгуулж 600 хүнд хүргэв.<br>-“Уухайн түрлэгт эх орон минь” 4 аймгийн хамтарсан хүндэтгэлийн тоглолтод 220 уран бүтээлч оролцож 520 хүн үзэж сонирхов.<br>-"Полифони" Дуэт болон Квартет дуучдын улсын уралдаанд Баянхонгор, Дорнод, Өвөрхангай, Дорноговь, Дархан-Уул, Улаан-Үд зэрэг нийт 6 аймаг, хотын 28 багш, 212 хүүхэд, багачууд оролцсон.<br>-"Миний дурсамжтай 35 жил" хүндэтгэлийн тоглолтыг 275 үзэгч үзэв.<br>- Сумдын соёлын төвд “T entertainment”-ын 9 кино, гадны 2 кино уран бүтээлийг нийт 445 хүнд үзэж сонирхуулав.<br>- “Өнөд өвлөгдөх аялгуу” хүндэтгэлийн концерт 2 удаа тоглогдож 1182 үзэгчдэд үйлчилсэн.<br>-“Кино хэлэлцүүлэг”-ийг ахлах ангийн 100 гаруй сурагчдын дунд зохион байгууллаа. Дархан хот кино урлагтай яаж холбогддог, кино хэрхэн бүтдэг, кино үйлдвэрлэл нь орон нутгийн эдийн засаг, нийгмийн соёлд хэрхэн нөлөөлдөг зэрэг олон талын мэдлэг ойлголтыг өгөв.<br>**Нийт 22 арга хэмжээ зохион байгуулсан.** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 32 | | | Дүрслэх урлаг, дизайн архитектурын мэдрэмжийг хөгжүүлэх үндэсний агуулга бүхий орон зайн хөтөлбөр, төслийн тоо | 9 | 5-аар нэмэгдүүлэх | -Дархан эмпати сургуульд "Урлагийн 7 хоног" уран зургийн үзэсгэлэн,<br>-"Солонго" гэрэл зургийн студи 25 жилийн ойгоо тохиолдуулан Залуучууд театр, ЕБ-ын 6 сургуульд "Дархан зураглал" гэрэл зургийн үзэсгэлэн,<br>- Дарханы зураач урчуудын эвлэлийн зураач Ч.Нарангарав, Б.Ариунбилэг нарын 20 гаруй шилдэг бүтээлүүдээс бүрдсэн "МЭДРЭХҮЙ" уран зургийн үзэсгэлэнг тус тус дэлгэсэн.<br>-Улаанбаатар хотноо "Инээдмийн баяр"-т зориулсан “ДӨРВӨН САРЫН НЭГЭН” шог зураачдын нэгдсэн үзэсгэлэнд МУСТА, МЗЭ-ийн гишүүн, “Утга зохиолын төлөө” хүндэт шагналт, шог зохиолч, Монголын шог зураачдын "Шогч бийр" холбооны гишүүн, шог зураач, тус аймгийн иргэн Д.Мянганзам 10 бүтээлээрээ оролцсон.<br>- “Зууны мэдээ” сонины “Дүрслэх урлагийн булан"-д Дархан зураач урчуудын эвлэлийн гишүүн, зураач С.Мөнгөнзул "Дөрвөн улирал" уран зургаар ярилцлага өгсөн.<br>- “Монголын сайхан орон” уран зураг, “Монгол бахархал”, “Бидний бахархал” гэрэл зургийн үзэсгэлэнг тус тус дэлгэв.<br>-“Хөрөг зураг” нээлттэй өдөрлөгийг зохион байгуулав.<br>-Дархан-Уул аймгийн музей, Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейтэй хамтран Б.Шаравын алдарт бүтээл болох "Монголын нэг өдөр" явуулын үзэсгэлэн дэлгэв.<br>-Аймгийн Музей, Улаанбаатар хот, Налайх дүүргийн иргэн пянз цуглуулагч Ц.Гантулгатай хамтран “The Batles Миний амьдралд” пянз цуглуулгын үзэсгэлэнг зохион байгуулж 355 иргэдийг хамруулав.<br>14."Чингис хаан ба түүний залгамжлагчид" маркны түр үзэсгэлэнг зохион байгуулав. | |
| 5 | | | Зорилт 5. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 33 | 1.2.4,<br>1.2.5,<br>1.2.6,<br>1.3.4<br>1.3.5 | Үйл ажиллагаа 5.1 Албан бус соёл, урлагийн боловсролын төвүүдийн үйл ажиллагааг сайжруулах, мэргэжил арга зүйгээр хангах, дэмжлэг үзүүлэх | Дэмжлэг үзүүлсэн соёл, урлагийн сургалтын төвүүдийн тоо | 12 | Дэмжлэг үзүүлсэн сургалтын төвийн тоог 10-аар нэмэгдүүлэх | Дэмжлэг үзүүлсэн соёл, урлагийн байгууллага, уран бүтээлчдийн тоо-21. Үүнд:<br>- Шинэ алхам сургуулийн бүжиг, дууны дугуйлангийн сурагчид “АВЬЯАСЛАГ ШИНЭ АЛХАМЧУУД” тоглолтыг 2 удаа,<br>- Гладнесс бүжгийн студийн сурагчид БНСУ-д зохион байгуулагдсан "World ballet grand prix” тэмцээнд оролцоход 4 удаагийн тоглолтыг Залуучууд театрт тус тус зохион байгуулж дэмжин ажиллалаа.<br>- Залуучууд театрын жүжигчин, МУСТА Ч.Дунгаамааг Косово хотод зохион байгуулагдах “Моно жүжгийн уралдаан”-д Монгол улсаас оролцоход Соёлын яаманд, Дархан хотын “Бундын тамга” хамтлаг БНСУ-руу аялан тоглолтоор явахтай холбогдуулан БНСУ-ын элчин Сайдын яаманд, “Шинэ алхам” сургуулийн “Очис” хамтлаг БНСУ-д олон улсын бүжгийн наадамд оролцоход тус улсын Элчин Сайдын яаманд, Япон улсад зохион байгуулагдах “Тайшо-Кото” уралдаанд оролцох “Шуранхай” хамтлагийн мэдээлэл болон дэмжлэг хүсэх тухай албан бичгийг аймгийн ЗДТГ-т хүргүүлж аргазүйн зөвлөгөө өгсөн.<br>- Нийтийн цэнгээнт бүжгийн “Ирээдүй” холбоотой хамтран төрийн байгууллагуудын дунд “Шугаман бүжгийн тэмцээн”-ийг зохион байгуулсан. Хамтран ажиллагч байгууллагуудаас 3,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.<br>- Олон улсын аварга шалгаруулах “LANDUO CUP-2024” нээлттэй тэмцээнд Дархан хотын "Sway dance academy" баг тамирчид амжилттай оролцлоо. Тус академийн мэдээллийг RGB телевизтэй хамтран нэвтрүүлэг бэлтгэн иргэд олон нийтэд сурталчиллаа.<br>-Шинэ алхам сургуулийн бүжгийн “Очис” хамтлагийн 17 сурагч 4 төрлийн бүжгээр 2024 оны 04 дүгээр сард БНСУ-ын СӨҮЛ хотноо зохиогдох K.U.A.C.E олон улсын бүжгийн 19 дэх уралдаанд Дархан хотоо төлөөлөн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оролцов.<br>-“Үндэсний бичиг-Манай хамт олон” цахим контент бэлтгэх уралдааныг хамтран зохион байгуулж Тусгай байрын шагналыг гардуулав.<br>-“Миний бахархал” бийр, хулсан үзгийн үзэсгэлэн гаргахад дэмжин ажилласан.<br>-“Угийн бичиг”-ийн уралдааныг зохион байгуулахад дэмжин ажиллав.<br>-Япон улсын Нийгата мужид зохион байгуулагдсан **Тайшо-Кото** олон улсын наадамд Дархан-Уул аймгийн ЕБС-ийн 5 сурагч Монгол улсаа төлөөлөн амжилттай оролцов.<br>- 15 дугаар сургуулийн Хөгжмийн багш Ж.Гүндэгмаагийн санаачилсан "Полифони" Дуэт болон Квартет дуучдын улсын уралдааныг дэмжин ажилласан. Тус уралдаанд Баянхонгор, Дорнод, Өвөрхангай, Дорноговь, Дархан-Уул, Улаан-Үд зэрэг нийт 6 аймаг, хотын 28 багш, 212 хүүхэд, багачууд авьяас чадвараараа өрсөлдсөн юм.<br>- Залуучууд театрын дэргэдэх "Шонхоодой" циркийн «Best of 2 Shonkhoodoi – “Шонхоодой циркийн шилдэг үзүүлбэрүүд 2» тоглолтыг дэмжин ажилласан.<br>- Хэнтий аймагт болсон Өсвөрийн циркчидийн улсын VI уралдаанд оролцох дарханы багт шатахууны дэмжлэг үзүүлсэн.<br>- Чөлөөт бүжгийн болон цэнгээнт бүжгийн, нийтийн бүжгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 18.0 сая төгрөг батлуулсан.<br>- Даймонд цирк, Улаанбаатар циркийн хамтын бүтээл "ТЭНГИСИЙН МӨРӨӨДӨЛ" олон улсын циркийн тоглолтыг Дархан хотын 63 жилийн ойн баяраар 2024 оны 10 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд нийт 6 удаа тоглогдсон. Тус циркийн тоглолтод орон нутгаас дэмжлэг үзүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 34 | | Үйл ажиллагаа 5.2 Соёлын боловсролын нийтлэл, нэвтрүүлэг, сурталчилгаа явуулахад хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах | Хамтран ажилласан байгууллагын тоо | 32 | 2-оор нэмэгдүүлэх | Орон нутгийн RGB, DBS телевизүүд зэрэг нийт 11 хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан. Тус хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дараах мэдээлэл, контентыг бэлтгэж иргэд олон нийтэд сурталчилсан байна. Тухайлбал:<br>- “Монгол түмний мэнд”, "Сайхан шинэлээрэй" нэвтрүүлэг, "21 Өв, соёл", "Ардын дууны түрлэг", “Хөлөгт тоглоом бол ой ухааны дасгал”, "Номонд дурлагсад”, "Эргэх дөрвөн цаг", “Шагайн наадгай”, “Найрамдлын Дархан өргөө” зэрэг нэвтрүүлэг бэлтгэсэн.<br>- МЗЭ-ийн Дархан салбарын тэргүүн, зохиолч Р.Лхамрагчаагийн "Сүбээдэй баатар" хөлгөн тууль, Улсын “Шилдэг уншигч анги хамт олон” "Мэдрэхүй" үзэсгэлэн, СББӨ-ийг өвлөн уламжлагч, Н.Мөнгөнбаяр, Ж.Эрхэмсайхан, Б.Түмэннаст, Т.Сарантуяагийн талаар ярилцлагын нэвтрүүлэг бэлтгэсэн.<br>-“Хүүхдийн уншлагыг удирдахуй”, “Үр дүнтэй уншлага” хэлэлцүүлэг, Хурдан уншлагын уралдаанын контент бэлтгэн цахимд байршуулсан.<br>- Музейн үзэл, баримтлал боловсруулах ажлын хэсгийн хурал, ОХУ-ын Буриад Улсын Зэдийн аймгийн уран бүтээлчдийн тоглолт, Залуучууд театр нь байгууллагад шилжин ирсэн ажилтныг орон байраар хангах ажлын явц, "Өв соёл ба Цагаан сар-II" уулзалт, хэлэлцүүлэг, Бие биелгээний сургалт, танхимын нээлт, Гладнесс бүжгийн төв "World Ballet Grand Prix Korea 2024" олон улсын уралдаанд амжилттай оролцсон тухай, "Sway dance” академи ЕврАзийн цом болон "Silk way-2024" ОУ-ын тэмцээнд оролцсон, “Эдип хаан” драмын жүжгийн талаар, Зураач, баримлалч Ц.Намдагийн шинэ уран бүтээлийн үзэсгэлэн, “Хөрөг зураг” өдөрлөг, Залуучууд театрын уран бүтээлчдийн ур чадварын уралдаан, “Бурхантын өвлийн наадам” 2024 эвэнт, “Миний хөөрхөн шүдний аялал”, “Өнөд өвлөгдөх аялгуу” хүндэтгэлийн тоглолт, “Дрифт”, “Найрамдлын Дархан” тоглолт, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Уламжлалт аргаар сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах”, "Эрүүл аж төрөх ёс" сургалт, “Янзын залуу минь яруу найраг зураглаач” номын нээлт, “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль, “Соёлын бүтээлч сар-2024”, “Мэргэжил бүхэн сайхан”, “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024”, “Миний хөөрхөн шүдний аялал”, “Дархан хот залуусын нүдээр”, “Монголын зохиолчдын эвлэлийн Дархан салбар” болон “Төв номын сан”-ийн 60 жилийн ойн баярын арга хэмжээ, Төвийн бүсийн номын санчдын сургалт, зөвлөгөөн, “Найргийн даага” яруу найргийн уралдаан, “Би зохиолч” хүүхдийн яруу найргийн наадам, “ “Номтой аялал”, “Мэргэжил бүхэн сайхан” аялал, “Гал Өд-2024” яруу найргийн наадам, “Номтой өдөр”, “Эх хэлний дархлаа”, “Зохиолчдын номтой өдөрлөг”, "Полифони" Дуэт болон Квартет дуучдын улсын уралдаан зэрэг нийт 250 гаруй мэдээ бэлтгэсэн. | |

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗАР